



# Зөвлөмжийн Цуврал

## ЗЦ139-2

Нэмэлт, өөрчлөлт 1 (2)

### Аэродромын гэрчилгээжүүлэлтийн Ерөнхий заавар

2021 оны 6 сарын 8

#### Ерөнхий зүйл

ИНЕГ-ын АС (АС) нь холбогдох ИНД-ийг дагаж мөрдүүлэх зорилгоор Даргын зөвшөөрсөн стандарт, практик, журмын талаарх мэдээллийг агуулдаг.

Даргад танилцуулах нийцлийн бусад аргыг ч анхаарч үзэх бөгөөд шинээр стандарт, практик, журам хүлээн зөвшөөрөгдөхөд холбогдох АС-д нь нэмж оруулна.

Түүнчлэн, энэхүү АС нь дүрмийн шаардлагыг хангах зааварчилгаа материалыг агуулна. Зааварчилгаа материал нь хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрт тооцогдохгүй.

#### Зорилго

Энэхүү АС нь ИНД-139-ийн аэродромын гэрчилгээжүүлэлтийн ерөнхий зааврын шаардлагад нийцэж байгааг үзүүлэх ИНЕГ-ын Дарга хүлээн зөвшөөрөх аргачлалыг агуулсан болно.

#### Холбоотой Дүрэм

Энэ АС нь ИНД-139.77 аэродромын гэрчилгээжүүлэлтийн ерөнхий заавар-тай шууд холбоотой болно.

#### Өөрчлөлтийн мэдэгдэл

Гишүүн улсуудын иргэний нисэхийн Дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг Дүрмийн зохицуулалтад шилжих Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 дугаар сарын 6-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн багц дүрмийг боловсруулсан.

ЗЦ139-2-ыг монгол болон англи хэл дээр боловсруулсан бөгөөд хэрэв эдгээрийн хооронд зөрүү гарсан тохиолдолд англи хэл дээрх хувилбарыг баримтална.

ЗЦ139-2-ыг NZ АС139-2-ын 2013 оны 1 сарын 30-ны өөрчлөлт 2-т үндэслэн боловсруулсан болно.

**Гарчиг**

<b>Нэгдүгээр бүлэг - Зориулалт ба хэлбэр.....</b>	<b>3</b>
1.1 Аэродромын гэрчилгээжүүлэлтийн ерөнхий зааврын зориулалт ба эрх зүй .....	3
1.2 Бэлтгэл ажил .....	3
1.3 Зохион байгуулалт .....	3
1.4 Агуулгын зохион байгуулалт.....	4
1.5 Тараалт түгээлт .....	4
<b>Хоёрдугаар бүлэг - Аэродромын ерөнхий зааврын агуулга.....</b>	<b>4</b>
2.1 Нийцлийн агуулга .....	4
2.2 Нийцлийн тусгай зүйл .....	4
2.3 Нарийн тодруулсан зааварчилгаа.....	4
<b>Гуравдугаар бүлэг - Аэродромын ерөнхий зааврын агуулга .....</b>	<b>7</b>
3.1 Жагсаалтын зорилго .....	7
3.2 Жагсаалтын талаар.....	7
3.3 ИНД -139-ийн шаардлага .....	7

## Нэгдүгээр бүлэг - Зориулалт ба хэлбэр

### 1.1 Аэродромын гэрчилгээжүүлэлтийн ерөнхий зааврын зориулалт ба эрх зүй

**1.1.1** Хэрэв аэродромын гэрчилгээжүүлэлтийн ерөнхий заавар (цаашид АГЕЗ гэх)-ын хамгийн чухал зүйл нь ИНД-ийн өргөтгөл гэж ойлгож болно. Учир нь ИНД-139 нь тухайн дүрэмд хамаарах бүх аэродромд ерөнхийдөө хангалттай нөхцөлөөр хамаарахаар бичигдсэн боловч тухайлсан тодорхой аэродром бүрийн онцлогийг хамаарч чадахгүй. АГЕЗ нь дүрмийн шаардлага ба аэродромын хэмжээ, үйл ажиллагаа, бүтэц, хэлбэрийг харгалзсан аэродром бүрийн тусгай шаардлага хоёрын дундах “гүүр” болж өгдөг.

**1.1.2 Иж бүрэн байх.** Тухайн аэродромд хамаарах ИНД-139-ийн бүх шаардлагыг АГЕЗ-тусгана. АГЕЗ нь дүрмийн шаардлагыг биелүүлэх, аэродромын үйл ажиллагаа явуулж буй ажилтанд хэрэгтэй мэдээлэл, журмыг агуулах зориулалт бүхий баримт бичиг юм.

**1.1.3 Уламжлалыг хадгалах.** ИНЕГ-аас тавих шаардлага тухайн аэродромд яаж хэрэгжиж байгааг үзүүлэх, шаардлагаас цааш илүү дэлгэрэнгүй нарийвчлахаас татгалзах нь зүйтэй. Хариуцлагын заавал байвал зохих тодорхойлолт, эрх бүхий байгууллага ба үйл ажиллагааны журам, урьдчилан төсөөлөөгүй нөхцөл байдалд нийцсэн уян хатан байдлыг хязгаарлаж болох хэт их нарийвчилсан түвшин эсхүл дүрмээр шаардаагүй үүрэг хариуцлага үүсэх нөхцөл байдал хоёрын хоорондох шугам, заагийг анхаарч харах хэрэгтэй.

### 1.2 Бэлтгэл ажил

Дүрмийн шаардлагаар АГЕЗ-т техникийн агуулгаас гадна байгууллагын бодит онцлог, бүтэц, зохион байгуулалтыг оруулсан байхыг шаарддаг. Тэдгээрийн талаар дараагийн мөрүүдэд өгүүлсэн болно. Та өөрөө АГЕЗ-аа бэлтгэн боловсруулж болох ба эсхүл хэн нэгнээр үүнийг хийлгүүлж болох юм. Энэ АС-ийг үргэлжлүүлэн үзэхэд хангалттай сайн АГЕЗ боловсруулахын тулд аэродромын үйл ажиллагааны бүх талын суурь мэдлэгтэй байх хэрэгтэйг харж болно. Алдаа мадаггүй, товч тодорхой, ИНД-139-ийн шаардлагыг үндэслэсэн тодорхойлолт, илэрхийлэл нь сайн баримт бичгийн шинж юм. ИНЕГ-аас үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрч аэродромын гэрчилгээ олгосон үед хэн бэлтгэсэн нь чухал биш, таны мөрдөн ажиллах баримт бичиг болно гэдгийг сана.

### 1.3 Зохион байгуулалт

**1.3.1** АГЕЗ-ын зохион байгуулалтын үндсэн гурван хэсэгт та анхаарал хандуулах хэрэгтэй. Эхний хэсэг нь бодит хэмжээс болон баримт бичгийн ерөнхий төлөвлөлт, дараагийн хэсэг нь баримт бичгийг бүрдүүлэх ажиллагаа, гуравдахь нь АГЕЗ-т оруулж буй материалыг хавсаргах дэс дараалал юм.

**1.3.2 Зааврын ерөнхий дизайн.** Хэрэв АГЕЗ нь тодорхой аэродромын бодит үйл ажиллагааг үзүүлсэн амьд, ажиллаж буй баримт бичиг бол, энэ нь хэрэглэж ашиглах, эргэн харахад дөхөмтэй байх хэрэгтэй. Хуудас таних системтэй байх нь маш чухал. Ямар баримт бичигт хамаарч буйг нь хялбар таньж болох хангалттай таних тэмдэг хуудас бүрд байх ёстой бөгөөд баримт бичиг дэх тодорхой байршлыг харуулсан байна. АГЕЗ нь нэмэлт өөрчлөлтийн бүртгэлийн хуудас, тухайн хуудасны агуулгыг багтаасан хяналтын хуудсыг багтаасан байна. Хуудасны дугаар, хажуу талд нь огноог үзүүлэх зайтай багана бүхий энгийн хүснэгт байж болно. Бүх хуудсыг дахин эргүүлэхгүй сонирхсон хуудас байгаа эсэхийг шалгахад маш хэрэгтэй зүйл бол хүснэгт юм. Энэ нь АГЕЗ-ыг ашиглах, эргэн харах, хянах, хуудсыг нэмж оруулах зэргийг хянах зориулалттай хяналтын хуудас болно.

**1.3.3 Бүрдүүлэх.** АГЕЗ нь харьцуулж болох үр дүнг харуулахын тулд хэвлэгдсэн байх ёстой. Эргүүлж үзэхэд тохиромжтой, стандарт хэмжээтэй, хар цагаан хуудастай, гурван цагираг орох нүхтэй байвал тохирно. Дахин хэвлэх, хуудас нэмэх, хасах, ялгаатай хэмжээтэй хуудас илгээх, эсхүл олон өнгийн баримт бичиг, өөр төрлийн дэвтэрлэх арга хэрэглэж болох гэх мэт үүсч болох асуудлыг анхаарах хэрэгтэй. Хуудасны нэг талд хэвлэх нь зүйтэй. Мөн их хэмжээний нэмэлт ороход эргэн харахад хялбар байх ба бэлэн иш татах үед хуудсыг харагдуулахад тохиромжтой байна.

#### **1.4 Агуулгын зохион байгуулалт**

Аэродромын ажилтан заавраас ишлэл, эх сурвалж авч, гарын авлага болгон хэрэглэж байгааг сайшаан дэмжих хэрэгтэй. Үүнийг тооцож, тухайн аэродромын зохион байгуулалт доторх ажил үүргийн чиглэлийг анхаарч үз. АГЕЗ-т буй зааварчилгааг хэрхэн хэсэгчлэн хуваахад энэ нь нөлөөлснөөр ажилтанд зааварчилгаа болох тусдаа хэсэгт хуваагдах юм. Ерөнхийдөө, дүрмийн хамаарах сэдэв нь өөрөө АГЕЗ-ын хамрах хүрээг хангалттай болгодог. Ялангуяа хянах, эргэн харах, нэмэлт өөрчлөлт оруулах процессын үед дүрмийн зүйл заалтад байгаа элементийн байрлалаар агуулгын зохион байгуулалттай хийгдсэн нь хялбар байдаг нь үнэн юм.

#### **1.5 Тараалт түгээлт**

Дүрмийн дагуу тухайн ажлыг хэрэгжүүлэх, гүйцэтгэх үүрэг бүхий аэродромын ажилтанд АГЕЗ-ын хамааралтай хэсгийг хүргүүлсэн байхыг шаарддаг. АГЕЗ-ын хэсэг тухайн ажлыг хэрхэн хийх ерөнхий зааварчилгаа биш юм. Харин АГЕЗ-ыг сайн боловсруулсан байх нь дүрмийн шаардлагын дагуу тухайн ажил хэрхэн хийгдэж, мөрдөгдөн хадгалагдаж байх талаарх мэдээллийг агуулсан байх явдал юм.

### **Хоёрдугаар бүлэг - Аэродромын ерөнхий зааврын агуулга**

#### **2.1 Нийцлийн агуулга**

АГЕЗ нь ерөнхий дүрмийн хувьд аэродромын ажилтан дүрмийг биелүүлэхэд шаардлагатай үйл ажиллагааны журам, төхөөрөмжийн тайлбар бичиг, үүрэг хариуцлага, бусад мэдээллийг агуулна.

#### **2.2 Нийцлийн тусгай зүйл**

Үйл ажиллагааны журам, төхөөрөмжийн үүрэг нь аэродром бүрд ялгаатай байдаг. Мөн ИНД 139- нийцэж байх \дүрмийн шаардлагыг биелүүлэх\ бүх АГЕЗ-т тусгах тодорхой зүйлийг дурдсан байгаа. Тэдгээр заавал тусгах зүйлийг хамгийн бага деталь шаардсан байсан ч анхаарах хандуулах хэрэгтэй. Ихэнх заалтыг тэдгээрийн тодорхойлсноос болон асуудал үүсэн гарахад тохирсон байхаар илүү дэлгэрэнгүй тайлбарлах хэрэгцээ үүснэ. Заалтын багахан хэсэг нь тусдаа үзүүлэн \зураг, хүснэгт, схем, аэродромын зааврын зураг, эсхүл диаграмм \таниулах материал хийн тухайн тодорхой заалтын талаарх ярилцлагад ишлэл болгон ашиглаж болохоос илүү тэдгээрт таарч тохирсон байж болно. Жнь: Зааврын туршид олон удаа нэг мэдээллийг давтаснаас энгийнээр байгууллагын зохион байгуулалтын схемийг зургаар болон дэс дарааллын шугамыг хүснэгтлэн үзүүлэн дараа нь ишлэл болгон ашиглах нь энгийн ойлгомжтой болно.

#### **2.3 Нарийн тодруулсан зааварчилгаа**

2.3.1 АГЕЗ-тай байх шалтгаан, зорилго, гол санааг ИНД-139-д заасан байдаг. Дүрмийн шаардлагыг биелүүлэн мөрдөхөд тухайн аэродромын ажилтанд туслах, хэрэгцээтэй ажлын баримт бичигтэй байх ёстой. Энэ АС-ийн 1.1-т заасан үндсэн хоёр зарчим энд

үйлчлэх болно. Бүрэн төгс боловсруулсан АГЕЗ дүрмийн нийцлийг хангах хангалттай зүйл чиглэлийг агуулсан боловч хэтэрхий нарийвчлахаас зайлсхийсэн байх хэрэгтэй. Хэрэв та аэродромын үйл ажиллагаа эрхлэгч бол таныг эзгүйд хэн нэгний хийх ажлын зааварчилгааг үлдээхэд сэдвийн хандлага оршино. Та өөрийн зааварчилгааг бичиж байхдаа энэ ажлыг **ХЭН** хийж дуусгах, ажил **ЮУ**-аас бүрдэж байгаа, ажлыг **ЯАЖ** хийх талаар аливаа тухайлсан зөвлөгөө, болон **ХЭЗЭЭ** хэрэг болох үед нь хийж гүйцэтгэх хугацаа зэрэгт анхаарал төвлөрүүлж болох юм. Эдгээр асуудлыг дор тайлбарласан болно.

**2.3.2 ХЭН. ХЭН** хэлэлцүүлэг хийхэд таарч тохироход хоёр асуудал байна. Харьцангуй автономит байдлаар таныг алга байхад ч ажлаа хэвийн явуулж байгаа **ХЭН**-танаас хамаарах хэдий ч таны эрх мэдлээс гараагүй ч гэхдээ бодит байдлаар, эсхүл үйл ажиллагаагаар бага зэрэг зайд орших **ХЭН**. Энэ нөхцөлд **ХЭН**-г бид тохиромжтой байхын тулд “бие даасан” гэж нэрлэе. Гол зүйл нь энэ **ХЭН** нь бодит байдал гэнэт өөрчлөгдсөн нөхцөлд ч үйлдэл хийх тухай шийдвэр гаргах тухай юм. Аэродромын хаа нэгтээ таныг байгаа үед ч гэсэн танаас зөвшөөрөл авалгүйгээр гэсэн утга. Өөр нэг **ХЭН** нь “орлогч” гэж нэрлэгдсэн бөгөөд ердийн үүрэг хариуцлагын болон эрх мэдлийн сүлжээнд түр зуур саатал гарсан нөхцөлд ч дүрмийн нийцлийг ханган ажил үүрэгт оролцон гүйцэтгэх ёстой. Энэ **ХЭН** нь энгийн ердийн үйл ажиллагаатай бүрэн танилцсан мэддэг, эсхүл огт танилцаагүй мэддэггүй байж болох ч зайлшгүй ажил үүргийг орлон гүйцэтгэдэг. АГЕЗ-т ажил үүргээ хэрхэн гүйцэтгэх талаар хангалттай зааварчилгааг оруулсан байх хэрэгтэй бөгөөд мэдээж хэрэг хэрэв ямар нэг асуудал гарсан үед дэмжлэг тусалцаа хүсэх талаар зааварчилгаанд тусгасан байх хэрэгтэй.

**2.3.3 “Бие даасан” ХЭН.** Дээр дурдсан тэр нэгэн “**ХЭН**” магадгүй эрх мэдэл, эсхүл үйлдлээрээ бүрэн бие даасан, чөлөөт биш ч гэсэн, асуудлын гол нь өдөр тутам хүсэлт гаргаж болон та нарын хооронд зөвшөөрөлцөх процесс хийгдэхгүйгээр тодорхой ач холбогдолтой үйлдлийг хийх юм. Тийм учраас аэродромын үйл ажиллагаа эрхлэгч тэр “**ХЭН**” нь хяналт зохицуулалтын талаас юу шаардахыг мэддэг, өдөр тутмын байнгын ажилд болон шинэ нөхцөл байдал үүсэх үед энэ мэдлэгээ хэрэглэж чаддаг гэдгийг итгэлтэйг мэдрэхийг хүснэ. Энэ талаар АГЕЗ-т тодорхой маш ойлгомжтой зааварчилгаа оруулан шийдэж болно. Аврах болон гал унтраах ажиллагааг дүрслэн үзүүлэх хэрэгтэй болдог. Тохiolдол гарахад галын депо дээр хаа нэгтээ маш их ач холбогдолтой байх яаралтай арга хэмжээ үйлдэл хийх шаардлага үүсдэг. Жнь: Хэрэв гал унтраах төхөөрөмжийн нэг хэсэг ажилгүй болсон үед, агаарын тээврийн үйл ажиллагааг хязгаарлах талаар зарим удидлагын арга хэмжээ авч болох, эсхүл тухайн аэродромыг ашиглаж байгаа агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэгчид энэ талаар мэдээлэх талаар байж болно. Яаралтай дуудлага хүлээн авангуут аэродромын онцгой нөхцөлийн төлөвлөгөөг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хэрэгжүүлэх үү гэсэн шийдвэр гаргах шаардлага ихэнхдээ үүсдэг. Ийм нөхцөлд эдгээр нөхцөлтэй нүүр тулан уулзаж буй аврах болон гал унтраах ажилтан зөв, товч тодорхой, боломжтой мэдээлэлтэй байснаар зөв чиглэлд арга хэмжээ авах боломжтой юу? Эцэст нь аль “**ХЭН**” нь зааварчилгаа өгч ажиллах талаар үүрэг хүлээсэн тухай тодорхой бичсэн байх ёстой.

**2.3.4 “Орлогч” ХЭН.** Та өөрөө, эсхүл таны томилсон байнгын төлөөлөгч байхгүй үед аль “**ХЭН**” нь тухайн ажлыг хийж гүйцэтгэж болох талаар бодох хэрэгтэй. Та энэ ажлыг хийх хамгийн туршлагатай нэгнийг урьдчилан сонгохыг хүсч магадгүй. Аэродромын үзлэгийн хөтөлбөрийг жишээ болгон хэрэглэе. Аэродромын үйл ажиллагааны талаар мэдлэгтэй боловч, ИНД-139-ийн шаардлагын талаар хангалтгүй ажилтны хувьд бүр гарааны шугамнаас эхлэн зааварчилгаа өгч эхлэхгүй байх. Гэхдээ тухайн ажилтан тухайн тодорхой үүргийг хэвийн гүйцэтгэж /шууд хянаж/ чадахгүй байж болох юм. Иймд АГЕЗ нь автомашинаар явах маршрут гэх мэтчилэн ажил гүйцэтгэх чухал шаардлагын талаар нарийвчилсан мэдээлэл агуулсан байх хэрэгтэй. Таны эзгүйд тухайн ажлыг хийж гүйцэтгэх талаар төлөвлөсөн байсан “**ХЭН**” биш, өөр нэгэн ажилтан уг хүнд

даалгаврыг гүйцэтгэдэг байж болох юм. Аэродромын гэрлийг ихэвчлэн шалгадаг танай цахилгаанчин жнь: тухайн өдөр эзгүй бол орлож байгаа “ХЭН” нь юу үзэж шалгаа мэддэг үү? Гэрлийг асаадаг унтраалга нь хаана байдгийг эхний ээлжинд мэдэж байна уу? Өөрөөр хэлбэл, “талбайн гэрлийг шалгах ажлыг холбогдох шаардлагын дагуу хийж гүйцэтгэнэ” гэсэн АГЕЗ-т байгаа үгс хангалтгүй байна гэсэн үг.

**2.3.5 ЮУГ ба ХЭРХЭН.** Дүрмийн шаардлагыг хангахын тулд тухайн ажил үүргийг хариуцсан, хийж гүйцэтгэхээр томилогдсон ажилтан, эсхүл алба нэгж **ЮУГ**, **ХЭРХЭН ЯАЖ** хийх тухай зааварчилгаа АГЕЗ-т туссан байна. Дүрмийн шаардлагатай ажил гүйцэтгэх үүрэг бүхий бүх ажилтан танилцаагүй тул, АГЕЗ-т хүссэн үр дүнг гаргахын тулд ажилты туршлага ба шаардагдах сургалтын талаар зааварчилгааг тодорхой бүтцээр оруулж өгөх шаардлагатай. Жнь, аэродромын үйлчилгээний баг нь ИНД-139-ийн аль шаардлагад аюулгүйн бүсийн гадаргуу болон аюулгүйн бүс бүрд хамаарах зай хэмжээний талаар заасан байдгийг мэдэхгүй бол “Дүрмийн шаардлагын дагуу бүх аюулгүйн бүсэд арчлалтын ажил явуулна” гэсэн зааварчилгааг АГЕЗ-т бичих нь асуудалтай юм. Харин аюулгүйн бүсийн бодит хязгаарыг тодорхойлон, яг аль хэсгийн гадаргууд арчлалт явуулах гээд байгаа тухай зургаар тодорхой үзүүлж харуулсан байх нь илүү тохиромжтой хэлбэр юм.

**2.3.6 ХЭЗЭЭ.** Ямар ч сайн зааварчилгаанд хэрэгжилт, үйлдэл байхгүй бол хангалттай үр дүн гаргахгүй. “аврах болон гал унтраах нэгж өдөр бүр сумалгааны талбайг шалгасан байна” гэсэн зааварчилгаа хангалттай тодорхой байж чадаж байна уу? Нэгдүгээр ээлжийнхэн хоёрдугаар ээлж энийг хийчих биз гэж бодоод, харин нөгөөдүүл нь нэгдүгээр ээлжийнхэн шалгасан байлгүй гэж тооцоод хэн нь ч хийхгүй тойрог үүссэн ажил болж болох уу? Цаг агаарын хүнд хэцүү үе гэх мэт нөхцөл үүссэн үед **ХЭЗЭЭ** шалгах вэ гэдэг чухал нөхцөл юм. Ямар нэг үйлдэл хийх үүрэгтэй ажилтан АГЕЗ-т маш тодорхой **ХЭЗЭЭ**-г уншиж чадах уу, эсхүл тодорхой бус бүрхэгдүү “Цаг агаарын хүнд хэцүү нөхцөл үүссэн үед” гэсэн зааварчилгааг унших уу? Мөн **ХЭН**, **ЮУГ**, **ЯАЖ** гэх мэт асуулт тухайн журам, эсхүл төхөөрөмжийг ашиглах бол энд үүсэн гарч ирж болно. Бодит нөхцөлд ихэнхдээ хоорондоо уялдсан **ХЭН**, **ЮУГ**, **ХЭЗЭЭ** нь тодорхой байх ёстой бөгөөд ихэнх зааварчилгаа тэдгээрийн хэрэгцээ шаардлагыг хангасан байх нь зүйтэй.

## Гуравдугаар бүлэг - Аэродромын ерөнхий зааврын агуулга

### 3.1 Жагсаалтын зорилго

ИНД-139-ийн бүх шаардлага гэрчилгээжсэн аэродромд хамаарна. Эдгээр аэродром нь ИНД-139-ийн шаардлагатай нийцэж байгаа арга хэлбэрийг тусгасан АГЕЗ-ыг боловсруулж, мөрдөж ажиллана. Жишээ, эсхүл тайлбарыг дэлгэрэнгүй тайлбарласан дүрмийн бүх гарчигийг багтаасан жагсаалтыг дор оруулав. Дүрэмд байгаа дарааллыг танилцуулгын хэлбэрээр давтав.

### 3.2 Жагсаалтын талаар

Захиргааны албан хэв маягтай шаардлагаас бусад хамаарах бүх зүйл энэ АС-ийн 2.3-т заасан шиг **ХЭН, ЮУГ, ЯАЖ, ХЭЗЭЭ** гэсэн асуултад тохирох хариулттай байхаар бичигдсэн байна. АС-ийн 2.2-т анхаарал хандуулах хэрэгтэй нийцлийн зүйл байна. Энэ жагсаалтанд багтсан жишээ болон сэдэв нь аэродромд гарч болох бүх нөхцөлийг багтааж чадахгүй. ИНД 139-ийн зарим шаардлагыг орхигдуулах нь тэдгээрийг биелүүлэх шаардлагагүй, эсхүл бага ач холбогдолтой гэсэн утга биш. Тухайн аэродромтой холбоотой энэ сэдэв, эсхүл жишээг хэрэглэснээр үүсч болох аливаа асуудлыг эрх бүхий байгууллагатай хамтран шийдвэрлэх ёстой.

### 3.3 ИНД -139-ийн шаардлага

#### 3.3.1 139.13 Аюулгүй байдлын үзлэгийн аудит

Та Даргын албан ёсоор эрх олгосон ажилтан ИНД-139-ийн шаардлагад нийцэж байгааг тогтоохын тулд аэродромд үзлэг шалгалт, аудит хийх, баримт бичиг, бүртгэлтэй танилцах бүрэн эрхтэй байх бөгөөд таны эзгүйд ч гэсэн аэродром хариуцсан этгээд мэдэж байх талаар АГЕЗ-т тусгасан байна.

#### 3.3.2 139.15 Дүрмийн шаардлагаас чөлөөлөх

Хэрэв аль нэг дүрмийн шаардлагаас чөлөөлөх заалт байгаа бол энэ нь тухайн аэродромын нийцлийн зурагт өөрийн хэрэглэх хүрээг хамарч байгаа. Ямар дүрмийн заалтаас чөлөөлөгдсөн, чөлөөлөлт юуг хамрах тухайгаа ойлгосон байх, өөрийн АГЕЗ-т яаж тохируулж оруулсан байх нь чухал.

#### 3.3.3 139.17 Дүрмийн шаардлагаас хазайх

Энэ заалтыг дүрмийн зөрчилтэй андуурч болохгүй. Энэ заалтын мөн чанар нь онцгой нөхцөлийн үед үзүүлэх хариу үйлдэл юм. Дүрмийн шаардлагаас хазайх тухай оновчтой нарийн тодорхойлолт өгөх хэцүү боловч дараах жишээ тус болж болох юм:

- тухайн агаарын хөлгийн хэмжээ аэродромын аврах болон гал унтраах категориос дээш, эсхүл шаардлагатай ил харааны туслах хэрэгсэл, тэмдэглэгээ ажиллахгүй тохиолдолд нислэгийн үед онцгой нөхцөл үүссэн агаарын тээврийн агаарын хөлөгт аэродромд буух зөвшөөрөл олгох нь дүрмийн шаардлагаас хазайх болно.

- аврах болон гал унтраах хүчин чадлыг нисэхтэй холбоогүй аэродромын гадна үүссэн онцгой нөхцөлийг арилгахад туслуулахаар явуулсан боловч энэ хүчин чадлыг шаардсан нисэх онгоцоор үйл ажиллагааг хэвийн явуулахыг зөвшөөрөх нь дүрмийн шаардлагаас хазайх биш зөрчил!

### **3.3.4 139.53 Аэродромын хязгаарлалт**

Аэродром дээр байгаа агаарын хөлгийн үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах зорилгоор тогтоох аливаа хязгаарлалтыг АГЕЗ-т оруулах ба ажилтан бүр дүрмийг биелүүлэхэд хэрэгтэй аливаа зааварчилгааны хамт тэдгээр хязгаарлалтын ач холбогдлыг мэдэж байх ёстой.

### **3.3.5 139.55 Ажилтанд тавих шаардлага**

Дүрэмд тусгай сургалт, эсхүл ур чадварын баримт бичиг шаардах салбараас бусад тохиолдолд эрх бүхий байгууллага сайн гүйцэтгэсэн ажиллагаа нь хангалттай мэргэшсэн боловсон хүчнийг харуулдаг гэж үздэг. Энэ шаардлага нь аэродромын удирдлагын болон хяналтын ажилтанд мөн хамааралтайг санах хэрэгтэй. Дүрмийн шаардлагын дагуу хариуцлагын тогтолцоог харуулахын тулд аэродромын үүрэг хариуцлагын шат дарааллыг үзүүлсэн хүснэгт, эсхүл схемтэй байвал зохистой.

Байгууллага гүйцэтгэх захирлаар тодорхойлогдсон хүнийг нэр дэвшүүлсэн байх шаардлагатай. АГЕТ-т заасан журам, ИНД-139-ийн шаардлагын хүрээнд үйл ажиллагаа явагдаж байгааг бататган, аэродром ба түүний байгууламжийг ашиглахад шаардлагатай нөөц хөрөнгө байгааг бататгахын тулд гүйцэтгэх захирал тухайн байгууллагын санхүүгийн эрх мэдлийг оруулцуулсан бүрэн эрх мэдэлтэй байна.

Тухайн аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн удирдлагын бүтцийг төлөөлөх нэр дэвшсэн этгээд, эсхүл этгээдүүд зөв тохирох хүн байх шаардлагад нийцэж байх ёстой. Хариуцлагын чиглэлийг бүхэлд нь, эсхүл хосолсон маягаар менежерийг томилохоор сонгож болох боловч хэнд ямар хариуцлага хүлээлгэж байгаа нь тодорхой байх ёстой. Ямар ч тохиолдолд тэдгээр менежер гүйцэтгэх захирлын өмнө бүрэн хариуцлага хүлээж түүний мэдэлд байх шаардлагатай. Ингэж нэр дэвшсэн хүмүүс САА24139/01 маягтын дагуу тодорхойлогдож, хүсэлтэд ур чадварын мэдээллийг хавсаргана. Тэдгээр нэр дэвшсэн хүмүүс хүлээн зөвшөөрөгдөхийн тулд аэродромын үйл ажиллагаатай холбоотой иргэний нисэхийн системийн талаар хангалттай туршлага, холбогдох мэдлэгтэй байх хэрэгтэй. Аэродромын байгууллагын ажлын цар хүрээ, хэмжээнээс хамааран нэр дэвшсэн этгээдийн албан тушаал, хариуцлага, тоо янз бүр байна.

Хариуцлага хүлээж буй дараах чиглэлээр нэр дэвшиж байгаа хүмүүсийн тоо, эсхүл ашиглаж болох албан тушаалаас үл хамааран аэродромын үйл ажиллагаанд таарч тохирох талаас анхаарал хандуулах нь зүйтэй.

### **Аэродромын үзлэг**

Байгууллагын Ерөнхий зааварт тодорхойлсон стандарт болон журмын дагуу бүх тогтмол хуваарьт болон үечилсэн үзлэг шалгалтыг хийж үр дүнг мэдээлж байгааг бататгах хариуцлагатай байна.

### **Аэродромын засвар, үйлчилгээ**

Илэрсэн бүртгэгдсэн аливаа эвдрэл, гэмтлийг цаг хугацаанд засварлаж, урьдчилан сэргийлэх засвар үйлчилгээний ажлыг явуулж байгааг бататгах хариуцлагатай байна.

### **Агаарын хөлгийг аврах болон гал унтраах үйлчилгээ**

Тухайн агаарын хөлгийн аврах болон гал унтраах төхөөрөмж болон бодис нь аэродромын категорийн хувьд бэлэн болон зөв түвшинд байгааг бататгахыг хариуцах. Энэ нь тухайн тээврийн хэрэгсэл болон төхөөрөмжийн хүчин чадлыг бүрэн хэмжээгээр ажиллуулахад сургагдсан хангалттай тооны ажилтныг бэлэн байлгах юм.



### ***Дотоод чанар баталгаажуулалт***

ИНД-139 болон АГЕЗ-ын нийцлийг бататгах чанарын баталгаажуулалтын журамтай байна. Аливаа үл тохирол илэрсэн үед түүнийг арилгах, залруулах арга хэмжээ авсан, бүрэн хэрэгжиж байгааг бататган, байгууламж болон үйл ажиллагааны хэмжээнд таарсан, ИНД-139-ийн шаардлага, холбоотой журам, аэродромын заавар, баримт бичгийн хүрээнд явагдаж буйг бататгах хариуцлага орно.

#### ***3.3.6 139.57 Аэродромын онцгой нөхцөлийн төлөвлөгөө /АОНЖ/***

Дүрмийн шаардлагад нийцсэн хүлээн зөвшөөрөхүйц АОНЖ-ын олон талыг багтаасан нарийвчилсан зааварчилгааг “ICAO Doc 9137-AN/898 Airport Services Manual Part 7 Airport Emergency Planning”-аас авч болно. АОНЖ нь АГЕЗ-ын зайлшгүй нэг хэсэг бөгөөд уг АС-ын 2.3-т хамаарах хариуцлага болон үйлдлийн талаарх тусгай зохицуулалтын арга хэмжээний гарын авлага юм.

#### ***3.3.7 139.59 Аврах болон гал унтраах - Категори тогтоох***

Аэродромын категори гэж юу вэ, аэродром дээр үйл ажиллагаа явуулдаг агаарын хөлгийн хувьд ямар утгатай болохыг тайлбарлах. Асуулт эрт орой хэзээ нэгэн цагт гарч ирэх тул тухайн категорид хамаарах хамгийн том нисэх онгоцны маягийг нэрлэх нь зүйтэй болов уу.

#### ***3.3.8 139.61 Аврах болон гал унтраах — Гал унтраах бодис***

Тухайн аэродромын категорид шаардлагатай гал унтраах бодисын хамгийн бага хэрэгцээт хэмжээг зарлах ба ингэхдээ нөөц хангалт ба сэргээн дүүргэх боломжийн талаар дурдахаа мартаж болохгүй. АС139/04 “Аэродромын аврах болон гал унтраах үйлчилгээ” нь тухайн АГЕЗ-т оруулж болох гал унтраах бодисын нэмэлт мэдээллийг өгнө.

#### ***3.3.9 139.63 Аврах болон гал унтраах тээврийн хэрэгсэл***

Аэродромын категорид шаардагдах минимум тээврийн хэрэгслийн тоог заах. Энэ нь тээврийн хэрэгсэл, эсхүл тээврийн хэрэгслийг, зөөвөрлөх гал унтраах бодис болон төхөөрөмжид тавих шаардлагатай дүйцүүлэх тохиромжтой цаг юм.

#### ***3.3.10 139.65 Аврах болон гал унтраах ажилтанд тавих шаардлага***

Ажилтанд тавих шаардлага нь үр дүнтэй аврах болон гал унтраах үйлчилгээний туйлын чухал элемент юм.

АС139/04 “Аврах болон гал унтраах үйлчилгээ” нь шаардлагатай хамгаалах хувцас хэрэгсэл, аврах болон гал унтраах төхөөрөмжийг багтаасан ажилтны талаарх дэлгэрэнгүй зааварчилгаагаар хангана. АГЕЗ нь аврах болон гал унтраах хариу арга хэмжээний дохиоллын системийн тодорхойлолт болон өдөр тутам тестийн шаардлагыг агуулсан байна. Түгшүүрийн дохионы системд НХҮ-ний үүрэг, тэдгээрийг шалгах талаар мөн заасан байх хэрэгтэй.

#### ***3.3.11 139.67 Аврах болон гал унтраах хариу арга хэмжээ авах чадвар***

Тухайн аэродромын категорид тохирсон аврах болон гал унтраах шаардлагатай элементээр хангах, энэ нь хариу арга хэмжээ авах чадварыг хангах зорилгоор аврах болон гал унтраах элементийг байршуулах тодорхой зааварчилгаатай байх юм. Тухайлбал, галын машин, аврах болон гал унтраах ажилтны бэлэн байдлын өдөр тутмын хяналтын системийг тогтоож баталгаажуулсан байхыг шаардана. Энэ чадвар нь

тухайн аэродромын онцгой нөхцөлийн төлөвлөгөөний эхний шат гэдгийг мөн мэдэж ойлгосон байх шаардлагатай.

Тухайн АГЕЗ-т журамласан байх ёстой хариу арга хэмжээ авах чадварын нэг тал нь тогтмол агаарын тээврийн үйл ажиллагааг 30-аас дээш гэрчилгээжсэн зорчигчийн суудлын багтаамжтай нисэх онгоцоор гүйцэтгэх үед үйлчилгээ үзүүлэх шаардлага юм. Тухайн аврах болон гал унтраах нэгж нь нисэх онгоц бүрийн хөдөлгөөний үед, эсхүл буухаас өмнө 15 минутын өмнө, хөөрсний дараа 15 минутын турш хариу арга хэмжээ авах чадвараа байнга хадгалж байх талаар зааварчилгаа авсан байх шаардлагатай. Нислэгийн хуваарьт аливаа өөрчлөлт орсон үед урьдчилан мэдэгддэг байхыг агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэгчид ойлгуулах нь чухал бөгөөд агаарын тээвэрлэгчтэй холбогдон хуваарьт нислэгийн өөрчлөлт, эсхүл аливаа хойшилсон нислэгийн мэдээлэл авах тухай журмыг АГЕЗ-т тусгасан байна.

### **3.3.12 139.69 Нийтийн хамгаалалт**

Энэ хэсэгт хамаарах дүрмийн зүйл нь санамсаргүйгээр хамгаалалттай бүсэд нэвтэрсэн этгээд агаарын хөлгийн нислэгийн үйл ажиллагаанд аюул учруулж болох нөхцөл бүрдэхээс сэргийлсэн шаардлага орно. Аэродромын аюулгүйн хамгаалалтыг санаатайгаар нэвтрэхээс сэргийлэх ажиллагаа энэ Дүрмийн D Бүлгээр зохицуулагдсан ба энэ шаардлагатай андуурах хэрэггүй. АГЕЗ-т хүн, тээврийн хэрэгсэл, эсхүл амьтан санамсаргүй нэвтрэхээс сэргийлж ямар арга хэмжээг авахыг тайлбарласан байх хэрэгтэй. Хашаатай байна гэдэг нь тодорхой арга ба анзаарагдахуйц тэмдэгт байрлуулах нь өөр зүйл юм. Хэрэв хаалгаа онгорхой орхиогүй, эсхүл тэмдэгт нь бүдэгрээгүй, арилаагүй, эсхүл халхлагдаагүй бол аль нь ч гэсэн сайн арга хэмжээ юм. ИНД-139-ийн шаардлагад нийцсэн харуул хамгаалалтын үргэлжилсэн байнгын хяналтын арга хэмжээг тухайн аэродромд хэрэгжүүлж байх талаар АГЕЗ-т тусгасан байна.

### **3.3.13 139.71 Мал, амьтан шувууны аюулаас сэргийлэх зохицуулалт**

Мал, амьтан, шувууны аюултай холбоотой асуудлаар тухайн АГЕЗ-т дараах гурван төрлийн тэмдэглэлээс аль нэгийг нь тусгана. Үүнд: Аюултай сөрөг үйлдлийн талаарх мэдэгдэл, аюултай гэж тооцоогүй үйлдлийн талаарх товч мэдэгдэл, эсхүл аюултай үйлдлийг бууруулах, эсхүл арилгах хүрээлэн буй орчны менежментийн хөтөлбөр.

Хэрэв тухайн аэродромд зэрлэг ан амьтны аюултай үйлдэл байхгүй, эсхүл хөтөлбөр хэрэгжүүлэх хэмжээний үйлдэл байхгүй бол тухайн АГЕЗ-т энэ нөлөөллийн талаар тусгасан байна.

Хэрэв тухайн аэродром дээрх зэрлэг ан амьтны үйлдэл нь хүрээлэн буй орчны менежментийн хөтөлбөрийн судалгааг шаардсан ба дараа нь хөтөлбөр шаардлагагүй гэж тодорхойлсон бол АГЕЗ-т судалгааны үр дүнд авах арга хэмжээ, цар хүрээ, ажлын төрлийг тогтоосон товч мэдээллийг АГЕЗ-т оруулсан байна. Энэ нь нөхцөл байдлыг дахин үнэлэх зэрлэг, ан амьтны аюултай холбоотой ажиглалтыг дараа нь явуулахад харьцуулах ойролцоо хэмжүүр үзүүлэлт болдог. Зэрлэг ан амьтантай холбоотой ямар нэг тусгай төрөл ажиглагдсан нөхцөлд нэмэлт оруулах үед хэрэгтэй заавар зөвлөгөө нэмэх, мал, амьтан, шувууны аюултай холбоотой үйлдэл хүлээн зөвшөөрөх хэмжээ, хязгаараас хэтрэх нөхцөл үүссэн тохиолдолд судалгааны материалыг эргэн харах тохиолдол үүсч болно.

Хэрэв тухайн шаардлагыг хүчингүй гэж үзээгүй бөгөөд аэродром заавал хүрээлэн буй орчны менежментийн хөтөлбөртэй байхыг тогтоосон бол энэ хөтөлбөр тухайн АГЕЗ-ын байнгын нэг хэсэг болох ёстой. Аэродромын ажилтанд зориулсан тусгай журам, заавар шаардагдах түвшинд байгааг бататгахын тулд энэ АС-ийн 2.3-т байгаа зааварчилгааг мөрдөх шаардлагатай.

### 3.3.14 139.73 Аэродромын өгөгдөл болон мэдээллийг зарлан мэдээлэх

Аэродромыг хэрэглэгчид тэдний ашиглаж байгаа нисэх онгоцны маягт тухайн аэродром нийцэж байгааг үнэлэхийн тулд Монгол улсын AIP-д зарласан өгөгдөл мэдээллийг ашигладаг. НМҮБ-аар дамжуулан агаарын тээвэрлэгчид өгөгдөл мэдээллийг цаг хугацаанд үнэн зөв мэдээлэх, эдгээр өгөгдөл мэдээлэл нь бодитой, сүүлийн хувилбар гэдгийг бататгасан байх нь хамгийн чухал. Аэродромын өгөгдөл болон мэдээллээр хангах журмыг тогтоохын тулд НМҮБ-тай дээрх шаардлагын талаар харилцан ярилцах хэрэгтэй. NOTAM мэдээ зарлах шаардлага үүсэх аэродромын нөхцөлийн аливаа өөрчлөлтийг түргэн мэдээлэхийн тулд тодорхой журам тогтоох ёстой. **ХЭН, ЮУГ, ЯАЖ, ХЭЗЭЭ** хийх талаарх үйл ажиллагааны журам чухал ба аюулгүй ажиллагааны функц үр дүнтэй ба үнэн зөв байлгахын тулд тодорхой анхаарал тавих хэрэгтэй. AC139/09 “Аэродромын өгөгдөл ба мэдээлэл” нь НМҮБ-д хүргэх мэдээлэл, өгөгдлийн талаарх дэлгэрэнгүй зүйлийг тусгасан болно.

### 3.3.15 139.75. Аюулгүй байдлын удирдлага

Энэ AC-д сүүлд тусгасан, ИНД-д заасан аэродромын үзлэгийн хөтөлбөр болон бусад хяналтын шаардлага нь чанарын удирдлагын тогтолцооны гол чухал элемент юм.

Үзүүлэлтийн стандартаас хазайлт илрэх болон аэродром дээр байгаа нисэх онгоцны үйл ажиллагаанд аюул учруулахаас өмнө тохирсон залруулах ажил хийгдсэн байхыг бататгахад чиглэсэн бие даасан чанарын удирдлагын тогтолцоо нь танай чанарын удирдлагын тогтолцоо юм. Чанарын удирдлагын тогтолцоо аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн одоо мөрдөж, хэрэгжүүлж байгаа баримт бичиг, үйл ажиллагааны журам, аэродромын байгууламжийн үзүүлэлтийг тогтмол хянаж шалгах ёстой. Эдгээр хяналт, шалгалтын ажил нь холбогдох бүх шаардлага, стандарт, журмыг зөв тодорхойлсон, баримт бичигт тусгасан, аэродромын үйл ажиллагаа явуулахад тохирсон, хэрэгтэй, нийцэж байгаа болохыг бататгах шаардлагатай. Чанарын удирдлагын тогтолцоо нь стандартын үл нийцлийн шалтгааныг шинжлэн шалгах, аэродромын үйл ажиллагааны аливаа элементийн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийх журамтай байх ёстой. Энэ журам нь хяналт шалгалт хийгдэж байх, хийгдэж дууссан үед болон хүсэлт гаргасан эрх бүхий байгууллагад тайлагнах систем ажиллаж байгааг харуулдаг.

Чанарын удирдлагын тогтолцоо дотоод хяналт шалгалтын үед ажиглагдсан, илэрсэн аливаа үл тохирол, дутагдлыг залруулсан байхыг бататган журамласан байна. Энэ үйл ажиллагааг Ерөнхий захирал бүрэн удирдаж, хариуцах ёстой.

Чанарын баталгаажуулалт нь ахлах албан тушаалтны хяналтан дор бие даасан тусдаа байх шаардлагатай. Тухайн аэродромын хэмжээ, үйл ажиллагаанаас хамаарч хэрэглэх журам, байгуулсан хэлбэр янз бүр байж болно. Энэ нь чанарын тогтолцоо үр дүнтэй ажиллаж байгааг бататгах удирдлагын хэрэгсэл бөгөөд үүнтэй уялдан аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн бодлого, чиглэл, үйл ажиллагаа, чанарын хяналтыг баталгаажуулах үүрэг, гүйцэтгэх журмыг тодорхойлсон ба бичсэн байна.

Хэрэв жижиг хэмжээний байгууллага бол, чанарын баталгаажуулалтын хяналт шалгалтыг бие даасан чадварлаг хувь хүнтэй гэрээ байгуулах эсхүл өөр зохицуулалтаар энэ ажлыг хариуцуулан хийлгүүлж болох юм.

Байгууллагын чанарын баталгаажуулалтын баримт бичигт:

- Аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн хүрэхээр тооцож буй чанарын түвшингийн талаарх ойлгомжтой тодорхойлолт
- Дотоод хяналт шалгалтын давтамж, түвшингийн журам

- Чанарын хяналт шалгалтын үл тохирол, дутагдлыг бүртгэх журам ба удирдлагад танилцуулах зааварчилгаа
- Хариуцах ажилтны жагсаалт
- Байгууламж ажиллахгүй болох мэдээлэл, зөрчил, санал гомдол, эвдрэл гэмтэл зэргийг бусад “чанарын үзүүлэлт”- үүд чанарын баталгааны системд тусгасан талаарх журам
- Удирдлагын ерөнхий төсөөлөл ба анализ хийх журам
- Илэрч болох аливаа дутагдал, доголдлыг залруулах журам
- Үзлэг шалгалтаас удирдлагын хяналт шалгалт хүртэлх хяналтын үйл ажиллагааг бүрэн дүүрэн баримтжуулах журамтай байх ба аюулгүй байдлын аудитын үед эрх бүхий байгууллагад үзүүлэх харуулах боломжтой байлгана.

Байгууллагын бүх түвшинд чанарын тогтолцооны бодлогыг ойлгосон, хэрэгжүүлсэн, нийцүүлсэн байхыг бататгасан арга хэмжээг авсан байна.

MNS 9001 (ISO 9001) “Чанарын баталгаажуулалтын чанарын тогтолцооны загварыг дизайн, хөгжүүлэлт, үйлдвэрлэл, суурилуулалт ба үйлчилгээний салбарт хэрэглэх” зохих дүрмийг дагаж мөрдөх чанарын тогтолцоо нь ИНД139.75 “Аюулгүй байдлын удирдлага” –ыг дагаж мөрдөх хүлээн зөвшөөрөхүйц аргачлал байна.

MNS 9004 Хэсэг 1 & 2 (ISO 9004) “Чанарын тогтолцоо ба чанарын тогтолцооны элементийн зааварчилгаа” нь чанарын систем тогтоох зааварчилгаа мэдээлэл болно.

### **3.3.16 139.103 Аэродромын засвар, үйлчилгээ**

Энэ болон бусад өргөн хүрээг хамарсан засвар үйлчилгээний төрлийн шаардлагыг АГЕЗ-т тусгасан байх шаардлагатай. Энэ АС-ийн 2.3-т заасан хэсгээс ишлэл авч, **ХЭН, ЮУ, ЯАЖ, ХЭЗЭЭ** гэсэн асуултын хариуг бичнэ. Аэродромын үзлэгийн хөтөлбөрийн дагуу хийсэн үзлэгээр ашиглалт, засвар үйлчилгээний шаардлагыг тогтооно. Залруулах ажил, засвар үйлчилгээг явуулахад ашиглалтын ажил хариуцсан ажилтанд хэрэгтэй журмыг АГЕЗ-ын энэ хэсэгт тусган оруулсан байх хэрэгтэй.

Нислэгийн үйл ажиллагаанд аюул учруулах хэмжээнд хүртэл аэродромын аливаа элемент эвдрэл гэмтэлд орохоос хамгаалсан урьдчилан сэргийлсэн засвар, үйлчилгээний хөтөлбөртэй байхыг ИНД-ээр шаарддаг.

Энэ шаардлага нь тодорхой график, хуваарийн дагуу хийгдсэн байх ба ашиглалтын ажилтанд зориулсан журмыг тусгасан байх хэрэгтэй.

Энэ хэсэгт тодорхой анхаарал хандуулахыг хүсч болох зүйл нь хучилтын гадаргуугийн бохирдол юм. Аэродромыг хэрэглэгч нарыг нөхцөл байдал, бохирдлын тусгай зааварчилгаа, мэдээллээр хангаж, ашиглагч бохирдлыг арилгах арга хэмжээг авч эхлэх талаар оруулна. Бохирдол хуримтлагдсанаас нисэх онгоцны үйл ажиллагааг тасалдуулахаас зайлсхийх нь таны ашиг сонирхолд нийцэх тул эдгээр нөхцөлийг урьдчилан тооцоолж, хэрэглэгчид аливаа саад учруулахыг багасгах зорилготой илрүүлэх болон арилгах хөтөлбөр боловсруулах нь зүйтэй.

### **3.3.17 139.105 Навигацийн ил харааны туслах хэрэгсэл, тэмдэглэгээний засвар үйлчилгээ болон шалгалт**

Засварын үйлчилгээний ажил нь эвдэрсэн, эсхүл алга болсон эд ангийг засах, эсхүл солих юм. Гэхдээ хэд хэдэн нэмэлт асуудалд анхаарах хэрэгтэй. Хэрэв гэрэл шатсан бол лампыг солих нь энгийн хэрэг. Гэхдээ гэрэл нь бүхэлдээ алга болсон, бүрэн эвдэрсэн бол түүнийг сольж буй ажилтан ямар хэлбэр дүрстэй гэрэл хэрэглэхээ мэддэг байхыг бататгасан байх нь чухал. Будган тэмдэглэгээний хувьд ч гэсэн ижил хэмжээний мэдээлэл шаардагдана. Аэродромын зураг хавсаргасан маш сайн боловсруулсан зааварчилгаа аливаа эд ангийг буруу байрлуулах, өөр зүйлээр солихоос хамгаалах үнэ цэнэтэй даатгал болдог.

Хэдэн удаа, ямар дарааллаар гэрэл шатахад нийт систем ажиллагаагүй гэж үзэх талаар АС 139/06 “МСТOW нь 5700 кг-аас дээш жинтэй нисэх онгоцонд ашиглах аэродромын дизайн”-д тайлбарласан шиг маш тодорхой зааварчилгааг оруулсан байх ёстой. Энэ нь ХБЗ болон ЯЗ-ын таних систем тодорхойлоход тохиромжтой хэсэг юм. Таних системээс гадна, хэрэв ялангуяа таних систем нь хэвийн байдлаас өөр, эсхүл төвөгтэй байвал ХБЗ, ЯЗ-ын зураг гаргахыг зөвлөж байна. Аэродромын гэрэлтүүлгийн талаар хэн хариуцаж байгаа болон хэрхэн харилцах аргачлалыг багтаасан байх ёстой.

Аэродромын эрх болон үүрэг хариуцлагын хүрээнд байх тэмдэглэгээтэй, эсхүл гэрэлтүүлэгтэй саадын байршлыг багтаасан байх ёстой. АГЕЗ-ын зураг, эсхүл карт, зай хэмжээний зурган дээр объектын байршлыг нь тайлбартай тааруулан заасан, өгүүлэн тайлбарласан байх хэрэгтэй.

Засвар үйлчилгээг өөр өөр байгууллага хариуцсанаас аэродромд олон саадын гэрлийн ойлгомжгүй байдал үүсэх тул чухам аль гэрэл нь хэний хариуцсан гэрэл болох, алийг нь танайх, алийг нь өөр байгууллага хариуцдаг талаар маш тодорхой заалтыг АГЕЗ-т тусгах хэрэгтэй. Мөн тог тасарсан үед тэдэнтэй хэн харьцах, хэрхэн ажиллах талаар тайлбар оруулсан байх ёстой.

Навигацийн зориулалттай ил харааны туслах хэрэгсэл, тэмдэглэгээ бүр хэрэглэгчид тохирсон заавар /техникийн паспорт, эсхүл техник үйлчилгээний заавар/ -тай байхыг энэ Дүрмээр шаардсан. АС139-3 “Аэродромын үзлэг”-д ил харааны туслах хэрэгсэл, тэмдэглэгээг газарт болон нислэгт шалгах талаарх зааварчилгаагаар хангах ба үүнийг ашиглан АГЕЗ-т оруулах боломжтой.

Үзлэг хийх журамд хэрэв аливаа гэмтэл согог илэрвэл залруулах ажлыг нэн даруй эхлүүлэх талаар журамласан байхыг бататгасан байна.

### **3.3.18 Зүйл 139.107 Аэродром дээр хийгдэх ажил**

Аэродром дээр хийгдэж байгаа ажлыг хянадаг болон эдгээр ажил нь агаарын хөлгийн үйл ажиллагаанд аюул учруулахгүй болохыг бататгах зорилгоор тогтоосон журамтай байх нь хамгийн чухал. Цаашдын зааварчилгааг АС139-5 “Аэродром дээр хийгдэх ажил”-аас авч ашиглаж болох ба АГЕТ-т заасан журам болон зааварчилгаанд тусгаж болно.

### **3.3.19 Зүйл 139.109 Аэродромын онцгой нөхцөлийн төлөвлөгөө**

Онцгой нөхцөл нь аэродромд цөөхөн тохиолдох байх гэж найдах боловч, аэродромын онцгой нөхцөлийн төлөвлөгөөг тогтмол сорил хийх, эргэн харж байх нь тухайн төлөвлөгөөний бодит үр дүнтэй байхыг хадгалахад чухал юм. Давтан хэлэхэд, хамгийн гол нь **ХЭН, ЮУГ, ЯАЖ, ХЭЗЭЭ** гэсэн асуултын хариултыг журамд тусган АГЕЗ-т багтаасан байна.

### **3.3.20 139.111 Аврах болон гал унтраах үйл ажиллагааны шаардлага**

Энэ хэсэг бол АГЕЗ-ыг боловсруулахад хамгийн их эрсдэлтэй хэсгийн нэг юм. Суурь бүтэц нь урьдын зүйлтэй ижил **ХЭН, ЮУГ, ЯАЖ, ХЭЗЭЭ** гэсэн асуултын хариу шаардлага юм. Энэ хэсэг нь аврах болон гал унтраах нөхцөл байдалтай холбоотой хэд хэдэн асуудлыг **ХЭН** бие даан хариуцах талаар тусгасан байна.

Аврах болон гал унтраах нэгжийн үзүүлж буй үйлчилгээ, үйл ажиллагааг бүрэн хянаж, зохицуулж чаддаг уу? Таны зөвшөөрөл, баталгааны хүсэлт гаргахаас өмнө хэдий хэмжээний зайтай байдаг вэ? Таны зөвшөөрөлгүйгээр тээврийн хэрэгсэл нисэх буудлаас гарч явах, эсхүл ямар нэг өөр ажил үүрэг гүйцэтгэж болох уу? Аврах болон гал унтраах үйл ажиллагаа, үйлчилгээ үзүүлэх боломжгүй болсон, эсхүл ямар нэг шалтгаанаар чадамжгүй болсон үед танд үнэн зөв мэдээлэл ирдэг үү? Эдгээр нь АГЕЗ-т аврах болон гал унтраах нэгжид хэрэглэх журмын талаар тусгахаас өмнө хариулт авсан байх ёстой үндсэн асуулт юм. Хэрэв та бүрэн, тогтвортой хяналт тогтоож чаддаг бол зорилт хэрэгжүүлэхэд их хялбар гэсэн үг. Аэродромын аврах болон гал унтраах нэгжид үүрэгт ажлын хүрээнд аль болох боломжит уян хатан байх боломжийг олгохыг хүсч болох ч агаарын тээврийн үйл ажиллагааг хамарсан шийдвэр гаргах үед түргэн шуурхай тохиромжтой мэдээллийн систем бүрдүүлсэн байхыг АГЕЗ-таа журамлан тусгасан байх хэрэгтэй.

Хэрэв аэродромд НХУ-ий нэгж үйлчилгээ үзүүлдэг бол аврах болон гал унтраах үйл ажиллагаанд маш том туслалцаа үзүүлнэ гэсэн үг. Онцгой нөхцөлийн үед тухайн нэгжийн үүрэг болон аэродромын удирдлага ба аврах болон гал унтраах нэгжийн хамтын харилцааны зохицуулалтын талаар тухайн нэгжтэй харилцан ярилцах шаардлагатай. Энэ тухай өөрийн АГЕЗ-таа бич. Бодит онцгой нөхцөлийн үед үл ойлголцол болон үр дүн муутай үйлдэл хийхээс сэргийлж, тодорхой хязгаарлалтаас цааш аврах болон гал унтраах нэгж үүрэг гүйцэтгэх боломжгүй талаар зааварчилгаандаа оруул. Аэродромд онцгой нөхцөл үүссэн үед тэдгээрийн оролцоо үүргийг тусгасан хамтран ажиллах журам НХУ-ий нэгжтэй байгуулсан байх нь аль аль талдаа хэрэгтэй юм. Хэрэв гэрээ, эсхүл журам байгаа бол АГЕЗ-таа хуулбарыг нь оруул.

Аврах болон гал унтраах түвшин байхгүй, эсхүл бага түвшинд байхыг шаарддаг нисэх онгоц ашиглах хугацаанд аврах болон гал унтраах ажиллагааг түр хугацаагаар бууруулахыг дүрмээр зөвшөөрсөн байдаг. Эдгээр нөхцөлийг АГЕЗ-т тодорхой тусгах нь зүйтэй. Танай АГЕЗ-т зэрэглэл бууруулах ажлыг хэрэгжүүлэх этгээд, эсхүл хүмүүс, байгууллагыг тодорхой тусгасан байх ба дагаж мөрдөх журам нь мөн тодорхой байна. Мөн аврах болон гал унтраах үйл ажиллагаа, үйлчилгээг буцааж сэргээн бүрэн хэмжээгээр бие бүрэлдэхүүн, төхөөрөмжийг ажиллуулах журам боловсруулсан байх бөгөөд АГЕЗ-т энэ талаар заавал тусгасан байх шаардлагатай. Мөн энэ талаар хариуцсан байгууллага, холбогдох үүргийг болон хэрэгжүүлж эхлэхээс өмнө нисэхийн мэдээллийн үйлчилгээний нэгжид мэдэгдсэн байх шаардлагатай талаар нарийвчлан АГЕЗ-т тусгасан байх ёстой.

АГЕЗ-т хамгийн энгийн харилцаа холбоог хэрхэн барих талаарх зааварчилгааг оруулсан байх ёстой. Хэрэв аврах болон гал унтраах нэгжид нэмэлт холбооны шугамаар бусад агентлагтай холбоо барих шаардлага байдаг бол ялангуяа онцгой нөхцөлийн оргил үед холбооны алдаа гарах боломж улам ихэснэ.

Ажиллахгүй байгаа машины талаар анхаарал хандуулсан заалтыг АГЕЗ-т оруулах ёстой. Дүрмийн шаардлагын хүрээнд “ажиллахгүй” гэдэгт яг юуг ойлгож байгааг тайлбарласан байхыг шаардана. “Ажиллахгүй” гэдэг нь тухайн машин бүх үүргээ гүйцэтгэх чадамжгүй болсныг ойлгоно. Гэхдээ энд жнь: тухайн машиныг аэродромоос

гадагш явуулсныг онцгой нөхцөлийн үед байхгүй байсантай адилтган үзэж болохгүй. Дагаж мөрдөх журмын талаарх маш тодорхой зааварчилгаа, аврах болон гал унтраах төхөөрөмж ажиллахгүй бол хэн хариуцаж уг ажлыг гүйцэтгэх ёстойг оруулна. Аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн хувьд аврах болон гал унтраах бэлэн байдлын талаар үнэн зөв, шуурхай мэдээлэлтэй байх ёстой бөгөөд энэ таныг агаарын тээврийн агаарын хөлгийн үйл ажиллагааг хязгаарлах болон мэдээлэх талаарх үүрэг хариуцлагыг гүйцэлдүүлэх боломжтой болгодог тэдгээр асуудлын нэг юм.

### **3.3.21 Зүйл 139.115 Апрон зохицуулалтын үйлчилгээ**

Апрон нь нисэх онгоц болон аливаа чухал газрын үйлчилгээний тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зохицуулах аюулгүй байдалтай холбоотой тогтоосон дүрэм болон журмыг мөрддөг аэродромын маневрлах талбайн хэсэг биш гэдгийг анхаарах хэрэгтэй. Дүрэмд шаардсаны дагуу юуны өмнө нисэх онгоц болон газрын үйлчилгээний тээврийн хэрэгслийн хөдөлгөөний тоо хэмжээг тогтоосны дараа апроны ашиглалтыг зохицуулах шаардлага, хэрэгцээ байгаа эсэхийг тодорхойлсон байна. Энэ үйлчилгээний зорилго нь нисэх онгоц хоорондоо, болон нисэх онгоц болон саадтай, эсхүл газрын үйлчилгээний тээврийн хэрэгсэлтэй мөргөлдөхөөс сэргийлэх юм.

Хэрэв тухайн аэродромд тус үйлчилгээ шаардлагатай гэж тогтоосон бол хэн тухайн ажлыг хийхийг тодорхойлж, шаардлагатай журам гарган, зааварчилгааг апроныг хэрэглэгчид болон ажилтанд өгнө.

### **3.3.22 139.117 Аэродромын үзлэгийн хөтөлбөр**

Энэ үйл ажиллагаа нь дүрмийн шаардлагыг хангахын тулд хийдэг маш олон бусад ажиллагаанд нөлөөлөх тул маш чухал ажиллагаа юм. Аэродромд үзлэг шалгалт хийх хөтөлбөрийн үүрэг нь аэродромын нөхцөл байдлыг хянах, дүрмийн бусад шаардлагын нийцлийг хангахад туслах юм.

АС139/03 “Аэродромын үзлэг” нь тухайн аэродромын цогц хөтөлбөрийг боловсруулахад тусална. Түүнчлэн, энэ АС-ийн 2.3-т тусгасан зааварчилгаа үр дүнтэй үзлэг шалгалтын хөтөлбөрийн бүх элементийг хамарсан байхад хэрэгтэй.

Тухайн аэродромд нисэх онгоцны хөдөлгөөнгүй байх тохиолдол байж болзошгүй тул өдөр тутмын үзлэг шалгалт заавалчгүй хийх шаардлагагүй гэдгийг анхаарах. Гэхдээ үзлэг шалгалтын хооронд хэт удаан тасалдал гарахаас сэргийлэх. Үзлэг шалгалт хийх аливаа хуваарь болон дагалдах үүрэг хариуцлагын тухай АГЕЗ-т заавал тусгасах.

### **3.3.23 139.119 Газрын үйлчилгээний тээврийн хэрэгсэл**

Газрын үйлчилгээний тээврийн хэрэгслийн хатуу хяналт аэродромын хөдөлгөөнт бүсэд олон асуудлыг анхааруулж чадах ба АГЕЗ-т тусгасан товч тодорхой журам нь энэ хяналтын бататгахад тусална.

Хэрэв аэродромд НХҮ үзүүлдэг бол АГЕЗ-т радио, эсхүл холбооны бусад шаардлагын талаар хамтран хүлээн зөвшөөрсөн аливаа дүрэм, журмын шаардлагыг тусгасан байх ёстой. Нисэхийн хөдөлгөөнт давтамж долгионд аливаа радио төхөөрөмжийн ажиллагаа нь ИНД-171-ийн холбогдох шаардлагын дагуу байна гэдгийг санаж байх хэрэгтэй.

Хэрэв аэродромд НХҮ байхгүй бол, эсхүл НХҮ байхгүй үед АГЕЗ-т газрын үйлчилгээний тээврийн хэрэгслийг тухайн хөдөлгөөнт бүсэд хэрхэн хянах, урьдчилан тохиролцож зохицуулсан тэмдэгт, эсхүл дохиог хэрэглэх журам тогтоосон байна.

Хэрэв, дүрмийн шаардлагад нийцсэн тээврийн хэрэгслийн сахилга батын талаар тусгай бичгээр байгуулсан гэрээг түрээслэгчидтэй хийсэн бол тухайн аэродромын ажилтанд

албадлагын арга хэмжээ авах талаар зааварчилгааг АГЕЗ-ын хавсралт болгон оруулах шаардлагатай.

### **3.3.24 139.121 Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууламж болон навигацгийн туслах төхөөрөмжийг хамгаалах**

Энэ нь навигацгийн туслах төхөөрөмжийн ажиллагааг бууруулж болох үйл ажиллагаанаас хамгаалах ажлын байр, эсхүл ажилтныг томилох талаар АГЕЗ-т тусгах тухай өөр нэгэн хэсэг юм. Навигацгийн туслах төхөөрөмжийн байршлаас шалтгаалан хашааг арчлах, тордох, харуул хамгаалалтын талаар тусгай журам бичиж, АГЕЗ-т тусгах шаардлага гарч болох юм.

### **3.3.25 139.123 Аэродромын нөхцөлийг зарлан мэдээлэх**

Тухайн аэродром дээр байгаа агаарын хөлгийн аюулгүй ажиллагаанд нөлөөлж болох аэродромын үйл ажиллагааны нөхцөлийг цаг алдалгүй агаарын тээвэрлэгчид мэдэгдэхийг дүрмээр шаардсан байдаг. АС139/03 “Аэродромын үзлэг” шаардлагын талаар Ерөнхий зааварт тусгах мэдээллийг агуулсан байдаг.

### **3.3.26 139.125 Аюултай нөхцөл**

Аюултай нөхцөлөөс сэргийлэх арга бол дүрмийн шаардлага бүрийг биелүүлэх арга хэмжээний тодорхой бөгөөд цаг хугацааны талаарх мэдээллээр аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийг хангах шаардлагыг эхнээс нь АГЕЗ-т тусгах. Аливаа илэрсэн нөхцөлийг мэдэгдсэн үед дүрмийн шаардлагын нийцлийг хадгалах зорилгоор хийх үйл ажиллагаа, арга хэмжээний талаар ажилтанд тодорхой зааварчилгаа өгөх ёстой. Хэрэв хэн нэгэнд үүргээ шилжүүлсэн, эсхүл эзгүй үед тухайн үүргийг хэн нэгэнд даалгасан бол дүрмийн шаардлагад нийцсэн аэродромын аюулгүй үйл ажиллагааг хангах аэродромын ажилтанд хэрэгтэй мэдээллийг АГЕЗ агуулдаг.

ИНД-139-ийн зарим шаардлага хэрэгжихгүй байгаа, залруулаагүй аюултай нөхцөл байдал тухайн аэродромд оршсоор байгаа бол тэдгээр бүсэд агаарын хөлгийн үйл ажиллагааг зогсоох шаардлагатай. Тухайн АГЕЗ-т хэрэв хэн нэгэн тийм аюултай нөхцөл үүссэнийг олж мэдсэн бол энэ мэдээллийг нэн даруй аэродромын эрх бүхий байгууллагын тодорхой түвшинд хүргэх ёстой гэдгийг аэродромын бүх ажилтан сайн мэддэг байхыг оруулсан байна.

### **3.3.27 139.127 Гэрчилгээ эзэмшигчийн байгууллагын өөрчлөлт**

Эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авахыг шаардсан 139.127.d-т зааснаас бусад өөрчлөлтийг АГЕЗ-т оруулснаа аль болох түргэн зохих хугацаанд эрх бүхий байгууллагад өөрчлөлтийн талаар мэдэгдэж байхыг шаарддаг. Энэ нь зөв санаа бөгөөд ялангуяа удаан хугацаа шаардсан, эсхүл төвөгтэй өөрчлөлт орж байгаа нөхцөлд эрх бүхий байгууллагыг өөрийн АГЕЗ-т нэмэлт оруулахаас өмнө өөрчлөлтийн төслийн талаарх мэдээллээр хангах юм. АГЕЗ-т орсон өөрчлөлт хүчинтэй болмогц, тухайн өөрчлөлтөд хамаарах аэродромын үйл ажиллагааны асуудал бүрд удирдлага тусгай анхаарал хандуулах шаардлагатай. Ихэвчлэн, ажлын журамд, эсхүл бусад шаардлагад өөрчлөлт ороход, өөрчлөлтийг тодорхойлох үүрэгтэй этгээд тухайн өөрчлөлтийг хийх бол өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд илүү хялбар байна. АГЕЗ хүчинтэй, зааврыг одоо хэрэглэж байгаа байдлаар нь хэрэглэж ашиглахыг дүрмээр шаардсан байдаг. Энэ нь маш их ажлын ачаалал, эсхүл харьцангуй жижиг энгийн даалгавар эсэх нь та хэрхэн яаж эргэн харах, нэмэлт өөрчлөлт оруулах, хянах процесс бэлдсэнээс шалтгаална.

**Сууриа сайн тавь.** Байнга санаж байх зүйлийнхээ жагсаалтад өөрийн АГЕЗ-ыг боловсруулж байхдаа баримт бичгийг хянах, нэмэлт өөрчлөлт оруулах процессыг нэмж оруул. Тухайн асуудлын талаар мэдлэгтэй хүнээр зохих хэсгийг хянуулахаар тооцож баримт бичгээ төлөвлөх. АГЕЗ-ын янз бүрийн хэсгийг хэнээр хянуулж дуусгах, хэзээ



хийхийг тодорхойлох. Хуваарь гаргах, түүнийгээ дагаж мөрдөх. Хэтрүүлэх хэрэггүй. АГЕЗ-ыг боловсруулах хуваарийг нэг цаг хугацаанд их ажлын ачаалал төвлөрөхгүй байхаар тооцох хэрэгтэй.

**Үйл явцыг тогтоох.** Хэнээр яаж хийлгэхээ шийдсэн бол, тэдгээрийг гүйцэтгэх ажилтанд энэ тухай мэдэгдэж, тэмдэглэх. Үүнийг бичиж тэмдэглэх хамгийн зөв АГЕЗ нь АГЕЗ өөрөө юм. Хэн, юуг, яаж хийх зааварчилгааг ашиглах. Тогтмол хуваарьтай хийгддэг хянах үйл явцын дундуур АГЕЗ-т өөрчлөлт оруулах, эсхүл нэмэх ажиллагааны талаар журамлаж болно. Ер нь цаг тухайд нь шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг хийх нь хамгийн зөв.

### **3.3.28 D Бүлэг Аэродромын аюулгүйн хамгаалалт**

НАБҮХөтөлбөр нь уг Бүлгийн шаардлагыг дэлгэрэнгүй тайлбарлах ба тухайн аэродромд шаардлагатай аюулгүйн хамгаалалтын байгууламж болон журмын тайлбараар хангана.

### **3.3.29 139.203 болон 205 Аюулгүйн хамгаалалтын сургалтын хөтөлбөр**

Дүрэмд заасан сургалтын шаардлага нь гэрчилгээ эзэмшигч гэрээ байгуулан, эсхүл хөлслөн ажиллуулж байгаа ажилтанд хамаарна.

139.203(8) болон 139.205(с)-д шаардсан аливаа сургалтыг аэродромын гүйцэтгэх захирлын хүлээн зөвшөөрсөн, сургалт явуулах сэдэв, агуулгын талаар шаардагдах түвшний мэдлэг, туршлага, ур чадвартайгаа харуулсан, сурч бэлтгэгдсэн аюулгүй байдлын сургагч багш удирдаж явуулна.

Анхан шатны болон давтан сургалт шаардлагатай хамаарах салбар, чиглэл нь гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий зааварт агуулсан аюулгүйн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх ажилтны ажлын онцлог, зэрэглэлээс хамаарч тогтоосон байх ёстой.

Сургалтын зарим хэсэг тухайн байгууллагын бүх түвшинд ижил байх ч, өгөх мэдлэгийн хэмжээ өөр өөр байдаг.

Сургалтын хамаарах хэсгийг боловсруулан, төлөвлөн, баримтжуулах энгийн ба тохиромжтой арга нь матрикс хүснэгт графикийг хэрэглэх юм. Энэ аргаар, аюулгүйн хамгаалалтын үйл ажиллагаанд хамаарах бүрэлдэхүүний зэрэглэл бүрийг босоо тэнхлэгт, шаардлагатай төрөл бүрийн сургалтын модулийг хэвтээ тэнхлэгт үзүүлэн жагсаасан. Үүгээр зэрэглэл бүрд тохирсон сургалтын хэсгийг ойлгомжтой харагдахуйц тодорхойлж, аюулгүйн хамгаалалтын сургалтын хөтөлбөрийг боловсруулах боломжтой гэсэн үг.

Энэ матрикс нь боловсон хүчний зэрэглэл тус бүрд мэдлэг, чадвартай байхыг шаардах журмыг тогтооно.

Гэрчилгээ эзэмшигч аюулгүйн хамгаалалтын шалгалтын журмыг бүрэн хамрахын тулд ажилтан бүрийн мэдлэг, чадварыг хангах хамаарал бүхий хэсгийн сургалтын хөтөлбөрийг боловсруулсан байна.

Тухайн аэродромын аюулгүйн хамгаалалтын нийтлэг шаардлагын хүрээнд ажилтны зэрэглэлд тохирсон аюулгүйн хамгаалалтын мэдлэг олгох сургалтыг явуулсан байна.

Ажилтан үргэлжилсэн мэдлэг, ур чадварыг хадгалж байгааг бататгахын тулд давтан сургалтыг 3 жилээс хэтрэхгүй давтамжтай дараах зааварчилгааг тусган явуулна:

- (a) эрх зүйн болон хяналт зохицуулалтын шаардлага болон стандартын өөрчлөлт
- (b) байгууллагын журам болон хөтөлбөрт орсон өөрчлөлт
- (c) байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлж байгаа аюултай хүчин зүйлийн өөрчлөлт

Гэрчилгээ эзэмшигчийн сургалтын үүрэг хариуцлагын талаар ИНҮАБХ-т тусгах хэрэгтэй.

Гэрчилгээ эзэмшигч нь тохиромжтой хэлбэрээр сургалтын үр дүнг үнэлэх журамтай байна. Эдгээр нь үзүүлэх, тайлбарлах, эсхүл шалгалтын хэлбэрээр байж болно. Тухайн журам нь сургалтанд хамрагдсан хүн бүр амжилттай сурсныг бататгахын тулд хөтөлбөрт багтсан ур чадвар бүрийг үйл ажиллагаа эрхлэгч хэрхэн бататгаж буйг харуулах шаардлагатай.

Ажилтны ур чадварын шаардлагатай минимум түвшинг үйл ажиллагаа эрхлэгч тогтоосон байх бөгөөд энэ нь шаардагдах түвшингийн шаардлагад нийцэж байгааг бататгахын тулд сэдэв болон хүн бүрд үнэлгээ тогтоох ёстой. Ур чадварын жишээг доор жагсааж үзүүлэв.

Ойлголтын түвшин ба холбогдох ур чадварыг сэдэв бүрд нь доорх байдлаар илэрхийлнэ.

- (1) 1-р түвшин - агуулгыг ойлгож байгааг харуулна.
- (2) 2-р түвшин - агуулгын үндсэн мэдлэгтэйг харуулна.
- (3) 3-р түвшин - ажилтны ажил үүргээ гүйцэтгэх үед үүсч болох нөхцөлд агуулгын үндсэн мэдлэгийг ашиглах боломжтойг харуулна.
- (4) 4-р түвшин - ажилтны ажил үүргээ гүйцэтгэх үед үүсч болох нөхцөлд агуулгын бүрэн төгс мэдлэгийг ашиглах боломжтойг харуулна.
- (5) 5-р түвшин - агуулгын бүрэн төгс мэдлэгийг ашиглах ба ажилтны ажил үүргээ гүйцэтгэх үед үүсч болох нөхцөлд бүрэн ашиглаж хэрэглэх боломжтойг харуулна.

Сургалтанд хамрагдах шаардлагатай ажилтан бүрийн сургалтын бүртгэлийг цэвэр нямбай, бүрэн бүртгэж хадгалах ёстой. Суралцагчийн бүртгэл хамрагдсан бүртгэлээс олон байх ёстой. Ажилтан хэзээ, хаана, ямар сэдэв, чиглэлээр суралцсан, үнэлгээний арга, шалгалтын үр дүнг үзүүлсэн байна. Бүртгэл нь аюулгүйн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд сургалтанд хамрагдсан тухайн ажилтны мэдлэг, ур чадварын үнэлгээний талаар бүрэн зураглалыг харуулах ёстой.